



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 7/212

Улаанбаатар хот

Г Монголын бүх ард түмний зуны XVI  
наадмын нэгдсэн заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, 30.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам"-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Монголын бүх ард түмний зуны XVI наадам"-ын нэгдсэн зааврыг хавсралтаар баталсугай.
- 2.Наадмын зохион байгуулалтыг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Зохион байгуулах хороо (О.Баттулга), Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтэс (Ж.Баасансүрэн)-т тус тус даалгасугай.
- 3.Спортын холбоодод холбогдох хууль, тогтоомж, наадмын нэгдсэн заавар, гэрээний заалтыг хэрэгжүүлэхийг зөвлөсүгэй.
- 4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Н.Батсүх)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БИЛЭГТ

142510783

Биеийн тамир, спортын улсын хорооны  
даргын 2025 оны 07 дугаар сарын 03  
-ны өдрийн 17:00 дугаар тушаалын  
хавсралт

МОНГОЛЫН БУХ АРД ТҮМНИЙ СПОРТЫН ЗУНЫ  
XVI НААДМЫН НЭГДСЭН ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, 30.3 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам"-ын хэрэгжилтийг хангасан байна.

Хоёр. Зорилго

Монголын бүх ард түмний спортын зуны XVI наадмын /цаашид наадам гэх/ зорилго нь улсын хэмжээнд биеийн тамир, спортын хөгжлийг эрчимжүүлэх, шинэ тутамд хөгжиж буй спортын төрлийг сурталчлан таниулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын оролцоог хангах, салбарын цаашдын чиг хандлагыг тодорхойлох, тив, дэлхий, олон улсын тэмцээн, наадамд өрсөлдөх тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэхэд оршино.

Гурав. Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын  
байгууллагын үүрэг, хариуцлага

3.1. Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороо нь анхан шатны тэмцээн болон сонгон шалгаруулалтыг нэгдсэн зааварт багтсан спортын төрөл, жин, зайд, ангиллаар зохион байгуулна.

3.2. Наадамд оролцох баг, тамирчдын спортын төрөл тус бүрд заасан насын хязгаарыг хатуу баримтална.

3.3. Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороо нь Тэмцээн, наадмын цахим бүртгэл хариуцсан ажилтныг тусгайлан томилж, баг, тамирчинтай гэрээ (цахим гэрээ) байгуулсан байна.

3.4. Наадамд оролцох баг, тамирчдыг анхан шатны тэмцээн болон сонгон шалгаруулалт хийж нэгдсэн зааврын дагуу Биеийн тамир, спортын тэмцээн, наадмын цахим систем ([cpanel.sport.gov.mn](http://cpanel.sport.gov.mn))-д заавал бүртгэх, бүртгэлийг баталгаажуулснаар тэмцээнд оролцуулна.

3.5. Анхан шатны тэмцээн болон сонгон шалгаруулалтаас шалгарсан баг, тамирчдыг шигшээ тэмцээнд оролцуулахад шаардагдах зардлыг Аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газар, Биеийн тамир, спортын газар, хороод бүрэн хариуцна.

3.6. Наадмын анхан шатны тэмцээн болон сонгон шалгаруулалтын үр дүн тайлан, шигшээ тэмцээнд оролцох баг, тамирчдын тоон болон нэрэн мэдүүлгийг 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор наадмын Зохион байгуулах хороонд [info@sport.gov.mn](mailto:info@sport.gov.mn) хаягаар ирүүлнэ.

3.7. Наадмын шигшээ тэмцээнд оролцох тамирчдыг үдэн гаргах, угтан авах үйл ажиллагааг зохион байгуулж, наадмын явцын мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлж, түгээн сурталчилна.

3.8. Баг, тамирчдыг тэмцээний өдрүүдэд дэх гэнэтийн ослын болон бусад холбогдох даатгалд харьяалах байгууллагын зүгээс зайлшгүй хамруулж даатгуулах үүрэг хүлээнэ.

3.9. Наадмын нээлт, хаалтын ажиллагаанд оролцох Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороо нь байгууллагынхаа лого бүхий түгийг барьж жагсана.

3.10. Наадмын нэгдсэн зааварт тусгагдсан тамирчны насын хязгаарыг санаатай болон санаандгүй зөрчиж Биеийн тамир, спортын тэмцээн, наадмын цахим систем ([cpanel.sport.gov.mn](http://cpanel.sport.gov.mn))-д буруу мэдээлэл оруулсан нь тогтоогдвол тухайн байгууллагын удирдлагад Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтыг үндэслэн хариуцлага тооцох үндэслэл болно.

## Дөрөв. Спортын холбоодын үүрэг, хариуцлага

4.1. Монголын бүх ард түмний спортын зуны XVI наадмын хөтөлбөрт багтсан спортын төрлийн холбоод нь Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 20 дугаар зүйл "Спортын холбоо, түүний эрх, үүрэг"-ийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллана.

4.2. Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрөл тус бүрийн тэмцээний зааврыг тухайн спортын холбооноос боловсруулан баталж, наадмын Зохион байгуулах хороонд ирүүлнэ.

4.3. Спортын холбоод нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо, наадмын шигшээ тэмцээнийг зохион байгуулах эрх авсан төв, орон нутгийн байгууллагатай "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулж, тэмцээнийг удирдан зохион байгуулна.

4.4. Спортын холбоод нь шигшээ тэмцээнийг зохион байгуулах эрх авсан төв, орон нутгийн байгууллагатай хамтран тухайн төрлийн шигшээ тэмцээний хөтөлбөр, бэлтгэл ажил, тэмцээн болох заал, танхим, талбайн тохижилт, тамирчдын аюулгүй байдал, шаардагдах спортын хэрэгсэл, хэрэглэл материал, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, нөөц хангамж, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа, нээлт, хаалт, шагнал гардуулалд, эмч шүүгч ажиллуулах, тамирчдын бие халаалт хийх орчин нөхцөлийг бүрдүүлэх, бусад зохион байгуулалтыг хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.

4.5. Спортын холбоод нь тухайн төрлийн шигшээ тэмцээнийг шүүн явуулах Шүүгчийн бүрэлдэхүүнийг томилон баталгаажуулж наадмын Зохион байгуулах хороонд тэмцээн эхлэхээс ажлын 10 хоногийн өмнө ирүүлсэн байна. Шүүгчийн зөвлөл нь тухайн спортын төрлийн техникийн зөвлөгөөнийг удирдан зохион явуулна.

4.6. Монголын үндэсний паралимпын хороо, Монголын диф спортын хороо, Монголын тусгай олимпын хороо, холбоод нь спортын төрлүүдийг зохион байгуулах ба шигшээ тэмцээнд оролцогч баг, тамирчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж, ангиллыг баталгаажуулах үүрэг хүлээнэ.

4.7. Спортын холбооноос томилогдсон тэмцээний ерөнхий шүүгч, маргаан таслах зөвлөл нь багийн ахлагч, багийн дасгалжуулагчаас гаргасан хүсэлт, гомдлыг шийдвэрлэнэ.

4.8. Шигшээ тэмцээний спортын төрөл тус бүрийг хариуцсан ерөнхий шүүгч нь тэмцээний үр дүнг гарын үсэг тамгаар баталгаажуулж наадмын Зохион байгуулах хороонд 2 цагийн дотор хүргүүлэн ажиллах үүрэгтэй.

### Тав. Оролцогч тамирчдад тавигдах шаардлага, оролцох журам

5.1. Наадамд оролцогч баг, тамирчин нь Монгол Улсын иргэн байна.

5.2. Наадмын оролцогч баг, тамирчин нь анхан шат болон сонгон шалгаруулалтад оролцсон Аймаг, дүүрэгтээ харьялгадана.

5.3. Наадамд оролцогч баг, тамирчин нь харьялгадах аймаг, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагаас зохион байгуулах наадмын анхан шатны тэмцээн болон сонгон шалгаруулалтад орж, нэгдсэн зааврын дагуу Биеийн тамир, спортын тэмцээн, наадмын цахим систем ([cpanel.sport.gov.mn](http://cpanel.sport.gov.mn))-д заавал бүртгүүлэх, тус бүртгэл нь албан ёсоор баталгаажилт хийгдсэнээр тэмцээнд оролцох эрх үснэ.

5.4. Нэг тамирчин - нэг байгууллага (аймаг, дүүрэг)-нэг спортын төрөлд оролцох ба сонгосон төрөлдөө тухайн спортын олон улсын дүрмийн дагуу зайд давхцан оролцож болно.

### Зургаа. Цахим бүртгэл

6.1. Наадмын зохион байгуулах хорооны цахим бүртгэлийн ажлын хэсэг нь цахим бүртгэлийн бүхий л үйл ажиллагааг хариуцаж, мэдээллээр ханган мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллана.

6.2. Цахим бүртгэлтэй холбоотой мэдээллийг шаардлагатай үед цахим хурал, цахим сургалтаар өгч, [www.sport.gov.mn](http://www.sport.gov.mn) цахим хуудсанд байршуулна.

6.3. Наадмын анхан шатны тэмцээн болон сонгон шалгаруулалтад оролцох баг, тамирчдын цахим бүртгэлийг 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 10:00 цагт нээж, 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 22:00 цагт хаана.

6.4.Наадмын шигшээ тэмцээнд оролцох баг, тамирчдын цахим бүртгэлийг 2025 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 10:00 цагт нээж, 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 22:00 цагт хаана.

6.5.Наадамд оролцогч баг, тамирчдын тоон болон нэрэн мэдүүлгийг батлагдсан загварын дагуу [info@sport.gov.mn](mailto:info@sport.gov.mn) цахим хаягаар файлаар ирүүлнэ.

6.6.Наадмын зохион байгуулах хорооноос баталсан цахим бүртгэлийн зааварчилгааг оролцогч байгууллагуудад 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс өмнө хүргүүлсэн байна.

#### Долоо. Наадмын зохион байгуулалт, хугацаа

7.1.Наадмыг ерөнхий удирдлагаар Зохион байгуулах хороо, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо ханган ажиллана.

7.2.Наадмын анхан шатны болон сонгон шалгаруулалтыг аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газар, Биеийн тамир, спортын газар, хороо нь 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө удирдан зохион байгуулна.

7.3.Анхан шатны тэмцээн болон сонгон шалгаруулалтын зохион байгуулалтад шаардагдах зардлыг тухайн Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороо хариуцна.

7.4.Наадмын шигшээ тэмцээнийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо, наадмын зохион байгуулах хороо, орон нутагт зохион байгуулах эрх авсан байгууллага, спортын холбоодтой хамтран 2025 оны 09 дүгээр сарын 15-21-ний өдрүүдэд зохион байгуулна.

7.5.Наадмын шигшээ тэмцээний зохион байгуулалтад шаардагдах зардлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо, орон нутагт зохион байгуулах эрх авсан байгууллага хамтран хариуцна.

7.6.Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрөл, тухайн төрлийн жин, зайд, ангилалд оролцох тамирчид нь наадмын шигшээ тэмцээний цахим бүртгэлд хангалтгүй бүртгэгдсэн тохиолдолд Зохион байгуулах хорооны хурлаар хэлэлцэж тухайн спортын төрөл, төрлийн зайд, жин, ангиллыг шигшээ тэмцэнээс хасах үндэслэл болно.

#### Найм. Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрөл, зохиогдох байршил

Монголын бүх ард түмний спортын зуны XVI наадам үндсэн 20 төрөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын 8 төрөл, нийт 28 спортын төрлөөр 2025 оны 09 дүгээр сарын 15-21-ний өдрүүдэд зохиогдоно.

8.1.Наадмын шигшээ тэмцээний хөтөлбөрт багтсан спортын 18 төрөл Баянхонгор аймагт зохион байгуулагдана.

8.2.Наадмын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын төрөл, мөн үндсэн төрлийн буудлага, хөнгөн атлетикийн шигшээ тэмцээн, нийт 10 спортын төрөл Улаанбаатар хотноо нэгэн зэрэг зохион байгуулагдана.

##### 8.3.Үндсэн 20 спортын төрөл:

- |                       |                    |
|-----------------------|--------------------|
| 1. Байт харваа        | 12. Спортын бүжиг  |
| 2. Бокс               | 13. Шатар          |
| 3. Буудлага           | 14. Самбо бөх      |
| 4. Волейбол           | 15. Таеквондо      |
| 5. Бадминтон          | 16. Футзал         |
| 6. Гимнастик          | 17. Хөнгөн атлетик |
| 7. Даам               | 18. Хүндийн өргөлт |
| 8. Дугуй /засмал зам/ | 19. Чөлөөт бөх     |
| 9. Жүдо бөх           | 20. Ширээний тенис |
| 10. Пауэрлифтинг      |                    |
| 11. Сагсан бөмбөг 5x5 |                    |

##### 8.4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын 8 төрөл:

- |                       |                          |
|-----------------------|--------------------------|
| 1.Пара хөнгөн атлетик | 5. Тусгай бочи           |
| 2.Хонхот бөмбөг       | 6. Тусгай хөнгөн атлетик |
| 3.Суугаа волейбол     | 7. Диф шатар             |
| 4.Пара жүдо бөх       | 8.Диф волейбол           |

8.5. Наадмын спортын төрлийн ангилал, төрөл, жин, зай, хүйс, тоо, хугацаа:

8.5.1. Үндсэн спортын төрлүүд

№	Спортын төрөл	Ангилал, төрөл, жин	Насны ангилал	Хүйс, тоо, зай	Шигшээ тэмцээнд оролцох тамирчид
1	Байт харваа	Ганцаарчилсан 70м	16 нас, түүнээс дээш (2009.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй, эмэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчид
		Багийн төрөл 70м		Эрэгтэй-3, эмэгтэй-3	
		Холимог баг 70м		Эрэгтэй Эмэгтэй	
2	Бокс	48-50кг, 55кг, 60кг, 65кг, 70кг, 75кг, 80кг, 85кг, 90кг +90кг	1985.01.01 2006.12.31 19-40 нас	Эрэгтэй, эмэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас жин тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин
		46-48кг, 51кг, 54кг, 57кг, 60кг, 65кг, 70кг, 75кг			
3	Буудлага	50м 3х20	18 нас, түүнээс дээш (2007.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй, эмэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин
		10м Хийн урт буу			
		10м Хийн гар буу			
		25м Спорт гар буу			
4	Волейбол	Баг	18 нас, түүнээс дээш (2007.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй-12, эмэгтэй -12	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас шалгарсан 1 баг
5	Бадминтон	Ганцаарчилсан	18 нас, түүнээс дээш (2007.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй, эмэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчид
		Хосын төрөл			
		Холимог хос			
6	Гимнастик	Уран сайхны гимнастик (ганцаарчилсан)	16 нас, түүнээс дээш (2009.12.31 -ээс өмнө төрсөн)	Эмэгтэй-1	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчид
		Аэробик бүжгийн баг		Хүйс хамаарахгүй 8	
7	Даам	100 буудалт даам	18 нас, түүнээс дээш (2007.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй, эмэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин
8	Дугуй	Засмал замын бөөн гарaa	17 нас, түүнээс дээш (2008.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй 150км	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас төрөл, зай тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин
		Ганцаарчилсан засмал замын гарaa		Эмэгтэй 90км	
				Эрэгтэй 40км	
				Эмэгтэй 25км	
9	Жүдо бөх	60кг, 66кг, 73кг, 81кг, 90кг, 100кг, +100кг	16 нас, түүнээс дээш (2009.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй, эмэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас жин тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин
		48кг, 52кг, 57кг, 63кг, 70кг, 78кг, +78кг			

10	Пауэрлифтинг	59кг, 66кг, 74кг, 83кг, 93кг, 105кг, 120кг, +120кг 52кг, 57кг, 63кг, 69кг, 76кг, 84кг, +84кг	18 нас, түүнээс дээш (2007.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй, эмэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас жин тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин
11	Сагсан бөмбөг 5x5	Баг	18 нас, түүнээс дээш (2007.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй-12, эмэгтэй-12	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас шалгарсан 1 баг
12	Бүжгийн спорт	Хос стандарт 5 бүжиг Хос латин 5 бүжиг Соло стандарт 5 бүжиг Соло латин 5 бүжиг	18 нас, түүнээс дээш (2007.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй, эмэгтэй Эмэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчид Стандарт (УВ,Т,ВВ,УФ,ХФ), Латин (С,Ч,Р,П,Ж)
13	Шатар	Ганцаарчилсан	18 нас, түүнээс дээш (2007.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй, эмэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин
14	Самбо бөх	58кг, 64кг, 71кг, 79кг, 88кг, 98кг, +98кг 50кг, 54кг, 59кг, 65кг, 72кг, 80кг, +80кг	18 нас, түүнээс дээш (2007.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй, эмэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас жин тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин
15	Таеквондо	54кг, 58кг, 63кг, 68кг, 74кг, 80кг, 87кг, +87кг 46кг, 49кг, 53кг, 57кг, 62кг, 67кг, 73кг, +73кг	17 нас, түүнээс дээш (2008.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй, эмэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас жин тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин
16	Футзал	Баг	16 нас, түүнээс дээш (2009.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй-14, эмэгтэй-14	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас шалгарсан 1 баг
17	Хөнгөн атлетик	100м, 200м, 400м, 800м, 1500м, 5000м, 10000м Уртын харайлт Өндрийн харайлт Гурвын харайлт Бөөрөнцөг тулхэлт Зээрэнцэг шидэлт 4x100м, 4x400м Холимог буухиа 4x400м	17 нас, түүнээс дээш (2008.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй, эмэгтэй Эрэгтэй-4, эмэгтэй-4 Эрэгтэй-2, эмэгтэй-2	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас шалгарсан зайд, төрөл тус бүрд 2 хүртэлх тамирчид
18	Хүндийн өргөлт	60кг, 65кг, 71кг, 79кг, 88кг, 98кг, 110кг, +110кг 48кг, 53кг, 58кг, 63кг, 69кг, 77кг, -86кг, +86кг	15 нас, түүнээс дээш (2010.12.31 -ээс өмнө төрсөн)	Эрэгтэй, эмэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас шалгарсан жин тус бүрд 2 тамирчин

19	Чөлөөт бөх	57кг, 65кг, 74кг, 86кг, 97кг, 125кг	18 нас, түүнээс дээш (2007.12.31 -ээс өмнө терсөн)	Эрэгтэй, эмэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас жин тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин
		50кг, 53кг, 57кг 62кг, 68кг, 76кг			
20	Ширээний теннис	Ганцаарчилсан	18 нас, түүнээс дээш (2007.12.31 -ээс өмнө терсөн)	Эрэгтэй, эмэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчид
		Багийн төрөл		Эрэгтэй-4, эмэгтэй-4	
		Эрэгтэй, эмэгтэй хос		Эрэгтэй-2, эмэгтэй-2	

#### 8.5.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын төрөл:

д/д	Спортын төрөл	Ангилал, төрөл, жин	Насны ангилал	Хүйс, тоо, зай	Наадмын шигшээ тэмцээнд оролцох тамирчдын тоо (ангилал тус бурд)
1	Пара хөнгөн атлетик	T11	18 нас, түүнээс дээш (2007.12.31-ээс өмнө төрсөн)	Эрэгтэй 800м Эмэгтэй 400м	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас зайд тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин
		T37, 38		Эрэгтэй 1500м Эмэгтэй 800м	
		T12, 13		Эрэгтэй, эмэгтэй 400м	
		T46		Эрэгтэй, эмэгтэй 1кг	
		T53, 54		Эрэгтэй, эмэгтэй 1кг	
		F33,34 зээрэнцэг		Эрэгтэй, эмэгтэй 1кг	
		F37,38 зээрэнцэг		Эрэгтэй, эмэгтэй 1кг	
		F55,56 зээрэнцэг		Эрэгтэй, эмэгтэй 1кг	
		F57 зээрэнцэг		Эрэгтэй, эмэгтэй 1кг	
		F32, 51 модон саваа		Эрэгтэй, эмэгтэй 397гр	
		F40,41 - 140см бөөрөнцөг		Эрэгтэй 4кг	
		F46 бөөрөнцөг		Эмэгтэй 3кг	
		F55, 56 Бөөрөнцөг		Эрэгтэй 6кг	
		F57 бөөрөнцөг шидэлт		Эрэгтэй 4кг Эмэгтэй 3кг	
2	Хонхот бөмбөг	Баг (хараагүй)	18 нас, түүнээс дээш (2007.12.31-ээс өмнө төрсөн)	Эрэгтэй-6, эмэгтэй-6	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас шалгарсан 1 баг
3	Суугаа волейбол	Баг			
4	Пара жүдо	-70кг, -81кг, -95кг, +95кг /J1,J2/  -52кг, -60кг, -70кг, +70кг /J1,J2/	18 нас, түүнээс дээш (2007.12.31-ээс өмнө төрсөн)	Эрэгтэй Эмэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин

5	Диф шатар	Ганцаарчилсан	18 нас, түүнээс дээш (2007.12.31- ээс өмнө терсэн)	Эрэгтэй-1, эмэгтэй-1	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин
6	Диф волейбол	Баг	18 нас, түүнээс дээш (2007.12.31- ээс өмнө терсэн)	Эрэгтэй-12, эмэгтэй-12	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин
7	Тусгай хөнгөн атлетик	L1-100м, L1-200м L2-100м, L2-200м	18 нас, түүнээс дээш (2007.12.31- ээс өмнө терсэн)	Эрэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин
		L1-100м, L1-200м L2-100м, L2-200м		Эмэгтэй	
8	Тусгай бочи	L1, L2	18 нас, түүнээс дээш (2007.12.31- ээс өмнө терсэн)	Эрэгтэй	Анхан шат болон сонгон шалгаруулалтаас төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин
		L1, L2		Эмэгтэй	

#### Ес. Тамирчдын тэмцээнд оролцох эрхийн баталгаажилт

9.1.Наадмын зохион байгуулах хороо нь олон улсын спортын холбооны тэмцээний дүрмийн дагуу анхан шатаас сонгон шалгаруулалтаар шалгарсан баг, тамирчдад наадмын шигшээ тэмцээнд оролцох эрхийг баталгаажуулна.

9.2.Наадмын зохион байгуулах хороо нь шигшээ тэмцээнд оролцох эрхийн баталгаажилтыг спортын төрөл тус бүрийн тэмцээн эхлэх хугацаанаас 10 хоногийн өмнө баталгаажуулна.

9.3.Наадмын шигшээ тэмцээнд оролцох эрх нь баталгаажсан баг, тамирчин нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шигшээ тэмцээнд оролцох боломжгүй болсон тохиолдолд спортын төрөл тус бүрийн эрхийн эцсийн баталгаажилт хийгдэхээс 6 хоногийн дотор Наадмын зохион байгуулах хороонд, нотлох баримтын хамт Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хорооны албан бичгээр мэдэгдэн, шийдвэрлүүлнэ.

9.4.Зохион байгуулах хорооноос тэмцээн, наадмын цахим системд бүртгэлтэй дараагийн эрэмбэлэгдсэн баг, тамирчинд анхан шатны тэмцээн болон сонгон шалгаруулалтын тайланг үндэслэн 4 хоногийн дотор эрхийг шилжүүлэн баталгаажуулна.

Арав. Сахилга бат, дэг журам

Монголын бүх ард түмний спортын зуны XVI наадамд оролцогч нь Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйл. “Биеийн тамир, спортод эрхэмлэн баримтлах ёс зүйн хэм хэмжээ”-д заасан хэм хэмжээг сахин мөрдөнө.

10.1.Спортоор дамжуулж тамирчдад сахилга бат, ёс зүйтэй байх, нийгэмд зөв хандлага, зэрэг нөлөөллийг бий болгоно.

10.2.Баг, тамирчин нь наадмын үйл ажиллагаа, тэмцээний заал, танхим, талбай, зам, гарaa, барианы тогтсон байршилд, нэгдсэн зохион байгуулалтад орж үүрэг хариуцлага, хувь хүний харилцаа хандлагыг бүрэн ухамсарлаж хэрэгжүүлнэ.

10.3.Өрсөлдөгч нараа хүндэтгэн, шударга өрсөлдөөнийг үзүүлнэ.

Арван нэг. Хүсэлт, гомдол шийдвэрлэх

11.1.Хүсэлт, гомдлыг зөвхөн тухайн багийн ахлагч, баг хариуцсан дасгалжуулагч нь бичгээр үйлдэн (шалтгаан, багийн нэр, хаяг, гарын үсэг, сар, өдрийг тодорхой бичих) өөрийн биеэр тухайн тэмцээний ерөнхий шүүгчид хандана.

11.2.Хүсэлт, гомдлыг спортын холбооноос томилогдсон тэмцээний ерөнхий шүүгч, маргаан таслах зэвлөл шийдвэрлэнэ.

11.3.Наадмын цахим бүртгэлтэй холбоотой гаргасан хүсэлт, гомдол нь үндэслэлтэй байх шаардлагатай бөгөөд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо, наадмын Зохион байгуулах хороо шийднэ.

Арван хоёр. Дүгнэх аргачлал, шагнал урамшуулал

12.1.Монголын бүх ард түмний спортын зуны XVI наадамд оролцогч байгууллагыг олон улсын спортын наадмын дүгнэх аргачлалын дагуу медалийн чанаараар дүгнэж байр эзлүүлнэ.

12.1.1.Наадмын шигшээ тэмцээнд амжилттай оролцсон 6 (зургаа) Аймгийг цом, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

12.1.2.Наадмын шигшээ тэмцээнд амжилттай оролцсон 3 (гурав) Дүүргийг цом, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

12.1.3.Зэвсэгт хүчин, онцгой байдал, хууль сахиулах байгууллагын спорт хороодоос шилдэг 1 (нэг) хороог тамирчдын хүртсэн медалийн тоогоор шалгаруулан цом, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

12.1.4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын төрөлд медалийн чанаараар амжилт гаргасан Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хорооноос байгууллагын дүнгээр эхний 3 (гурав) байр эзлүүлэн цом, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

12.1.5.Спортын төрөл тус бүрд медалийн чанаараар байгууллагын дүн гаргаж, медаль, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

12.2.Монголын бүх ард түмний спортын зуны XVI наадмын үндсэн болон хөгжлийн бэрхшээлтэй спортын төрлийн шигшээ тэмцээнд амжилттай оролцож, медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчдад Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 173 тогтоолоор батлагдсан “Үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам”-ын дагуу мөнгөн шагналаар шагнана.

---00---